

## **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ**

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр өөрийн албан ёсны цахим хуудас болох [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn) хаягт хуулийн төслийг албан ёсоор байршуулж иргэд, олон нийт, холбогдох этгээдийг хуулийн төсөлтэй танилцах, саналаа өгөх, хэлэлцүүлэгт оролцох боломжоор ханган ажиллав.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, редактор, хэвлэл мэдээллийн эзэд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн судлаач болон салбарын эрх зүйн судлаач гэсэн 4 үндсэн хэсэгт хуваан 2024 оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд 4 удаа зохион байгуулав. Хэлэлцүүлэгт нийтдээ 200 орчим сэтгүүлч, хэвлэл мэдээлэл, төр-иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцов. Хэлэлцүүлэгт төрийн төлөөллөөс УИХ-ын гишүүн Д.Энхтуяа, сэтгүүл зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачид болон салбарын эрх зүйн судлаач, хуульч, бусад иргэний нийгмийн байгууллага, холбоодоос төлөөлөл оролцлоо.

Хуулийн төслийн 4 удаагийн хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл биечлэн оролцож, хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалтын талаар мэдээлэл өгч, асуултад хариулж ажиллав.

Хэлэлцүүлгийн явцад хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан саналыг бүлэглэн, хууль тогтоомжтой нийцсэн, олонх дэмжсэн саналуудыг хуулийн төсөлд тусган ажилласан.

Түүнчлэн, шүүх, прокурор, төрийн захиргааны төв байгууллага болон хэвлэл мэдээллийн салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг нийт 35 байгууллагад хуулийн төслийг албан ёсоор хүргүүлж, саналыг авсан болно.

Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудаст байршуулсан хуулийн төсөлд олон улсын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний индексийг жил бүр эрэмбэлэн гаргадаг Хил хязгааргүй сэтгүүлчид /RSF/ олон улсын байгууллага, Ашгийн бус хуулийн олон улсын /ICNL/ байгууллагаас саналаа ирүүлсэн.

Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төвөөс хуулийн төсөлтэй холбогдуулан цуврал онлайн хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн сайд, Ашгийн төлөө бус хуулийн олон улсын байгууллагын (ICNL) хуулийн зөвлөхүүд болон Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал нар оролцож хуулийн төсөлд санал, зөвлөмж өгч, тодруулга хийв. 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн онлайн хэлэлцүүлэгт Хил хязгааргүй сэтгүүлчид /RSF/ олон улсын байгууллага, Глоб интернэшнл ТББ, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сэтгүүл зүйн инноваци, Хөгжлийн үүр төв зэрэг байгууллагууд оролцсон. Хэлэлцүүлгийн бичлэг, орчуулгын хамт зохион байгуулагчийн албан ёсны цахим хуудаст байршсан болно.

### **ХУУЛЬ САНААЧЛАГЧ**